

МЕНТОР ХӨТӨЛБӨР



Энэхүү ментор хөтөлбөрийг ISSK-ийн оюутнуудад олон талт дэмжлэг үзүүлэх зорилгоор 2019 оноос хэрэгжүүлж эхэлсэн. Менторууд нь өөрсдөө JGU-ийн оюутнууд бөгөөд тэдний ихэнх нь ISSK-ийн төгсөгчид юм. Ингэснээр ISSK-ийн оюутнуудын ирээдүйн талаарх төсөөлөл илүү тодорхой болж, ижил түвшинд харилцах боломжтой болно.

Менторууд юу хийдэг вэ?

Менторууд нь ISSK-ийн оюутнуудтай төрөл бүрийн сувгаар холбогдох ба Германд анх хөл тавих үеэс их сургуульд элсэх хүртэл туслахад хэзээд бэлэн байна.

Үүнд дараах зүйлс хамаарна:

- Герман болон ISSK-д хөл тавихад туслалцаа үзүүлэх
- Нийгмийн амьдрал болон академик орчинд дасан зохицоход туслалцаа үзүүлэх
- ХБНГУ-ын боловсролын орчин, ялангуяа JGU-д суралцах тухай танилцуулга
- JGU-д өргөдөл гаргахад туслах

Мөн түүнчлэн менторууд семестрийн туршид дараах арга хэмжээнүүдийг зохион байгуулдаг: Хот болон оюутны хотхонтой танилцах аялал, кино үдэш гэх мэт. Ингэснээр оюутнууд Майнц дахь оюутны амьдралтай танилцаж, санал бодлоо солилцох, харилцаа холбоо тогтоох боломжтой.

DOWNLOAD-CENTER

Weitere Informationen: Broschüren, Videos, Podcast, ...



<https://www.issk.uni-mainz.de/issk-downloads/>

Холбоо тогтоох

ISSK – Internationales Studien- und Sprachenkolleg

Johannes Gutenberg-Universität Mainz

Binger Str. 14-16 | 55122 Mainz



<https://www.issk.uni-mainz.de/>

Johannes Gutenberg-Universität Mainz
55099 Mainz



<https://www.uni-mainz.de/>

Fotos © Thomas Hartmann/JGU (Titelbild) | Alexander Sell/JGU | Moussa Ali



МАЙНЦ ХОТЫН ИХ СУРГУУЛИЙН ӨМНӨХ БЭЛТГЭЛ КОЛЛЕЖ

Монгол дахь түнш сургуулиудад зориулсан түвшин тогтоох шалгалтын (ТТШ) бэлтгэл курс

Internationales
Studien- und
Sprachenkolleg



БЭЛТГЭЛ КОЛЛЕЖ

Йоханнес Гутенбергийн нэрэмжит Их сургуулийн (JGU)-ийн дэргэдэх Олон улсын хэлний бэлтгэл коллеж (ISSK)-д суралцах шалтгаан:

- Түвшин тогтоох шалгалтад системтэй, эрчимтэй бэлдэнэ
- Туршлагатай багш нарын мэргэжлийн зөвлөгөө
- DSD I диплом олгодог түнш сургуулиудын төгсөгчид герман хэлний сургалтад нэг семестер хамрагдана
- ISSK-ийн төгсөгчдийн ментор хөтөлбөр
- Хувь хүнд нийцсэн элсэлтийн цахим шалгалтад бэлтгэх бие дааж суралцах онлайн курс
- Монгол улсад явагдах элсэлтийн цахим шалгалт
- Олон төрлийн медиа хэрэгслээр тоноглогдсон хичээлийн анги танхимууд

JGU-ийн оюутнуудад санал болгож буй зүйлс:

- Рейн-Майн мужийн төвд орших Олон улсын их сургуулийн оюутны хотхон
- Оюутны холбооноос санал болгож буй хотын 10 өөр байрлалд орших 4200 орчим оюутны дотуур байр
- Семестерийн тасалбараар Рейн-Майн мужийн бүхэлд автобус болон трамбайгаар зорчих
- Майнц хотын театрт үнэ төлбөргүй нэвтрэх болон чөлөөт цагаа идэвхтэй өнгөрүүлэх олон газарт хөнгөлөлттэй үнээр үйлчлүүлэх
- Оюутны хотхонд санал болгож буй 70 гаруй төрлийн спортын олон талт арга хэмжээ

ISSK-д элсэх өргөдөл гаргахад анхаарах зүйлс:

- Өргөдөл гаргах үед суралцагч бүрэн дунд боловсролын гэрчилгээг нэг жилээс хэтрэхгүй хугацаанд авсан байх
- Их сургуульд элсэх шалгалтад тэнцсэнг нотлох бичих
- Гэрчилгээ болон орчуулгыг нотариатаар баталгаажуулах шаардлагатай

Өргөдөл гаргахтай холбоотой мэдээлэл:

<https://www.studium.uni-mainz.de/meine-bewerbung/bewerbungsverfahren/bewerbungsunterlagen/>



Суурь хичээлүүд	Элсэлт авах хичээл	Судлах хичээлүүд
S-/G курс Гадаад хэл, хүмүүнлэгийн ухаан, урлаг болон нийгмийн ухааны чиглэлийн сургалт	• Хүмүүнлэгийн шинжлэх ухааны суурь	• Герман хэл* • Нийгэм судлал • Түүх • Хүмүүнлэгийн шинжлэх ухааны суурь
T-курс Математик технологи болон байгалийн шинжлэх ухаан	• математик	• Герман хэл* • Физик • Хими • Математик • Мэдээлэл зүй
W-курс Нийгэм болон эдийн засгийн ухаан	• математик	• Герман хэл* • Эдийн засаг • Математик • Нийгэм судлал

* Зөвхөн DSD I болон DSD II дипломтой суралцагчид ТТШ-ын хүрээнд герман хэлний хичээл болон шалгалтаас чөлөөлөгдөнө

JGU-ийн сургалтын хөтөлбөрийн болон ISSK-ийн суурь хичээлүүдийн тойм:



<https://www.studium.uni-mainz.de/studienwahl/studienangebot/>

СУРГАЛТЫН ЯВЦ

DSD II дипломтой бол:

Хаврын семестер / намрын семест эхлэх

4-р сар / 9-р сар	Монгол улсад элсэлтийн цахим шалгалт өгөх
Хугацаа 5-р сарын 15 / 11-р сарын 15	Элсэлтийн шалгалтад тэнцсэний дараа JGU-д элсэх хүсэлтээ онлайнгаар гаргах
2-р сар / 7-р сар	Бэлтгэл коллежид элсэн орох болзолыг хангах
Майнц руу нүүх <small>JOHANNES GUTENBERG UNIVERSITÄT MAINZ JGU</small>	
2-р сар / 8-р сар	Бүрэн дунд боловсролын гэрчилгээг баталгаажуулах
2-р сар – 7-р сар / 8-р сар – 1-р сар	ISSK-ийн үндсэн сургалтад амрагдах
7-р сар / 1-р сар	ТТШ-д тэнцсэний дараа мэргэжлийн сургалтад хамрагдах

DSD I дипломтой бол:

Зөвхөн намрын семест эхэлнэ

4-р сар	Монгол улсад элсэлтийн цахим шалгалт өгөх
Хугацаа 5-р сарын 15	Элсэлтийн шалгалтад тэнцсэний дараа JGU-д элсэх хүсэлтээ онлайнгаар гаргах
7-р сар	Бэлтгэл коллежид элсэн орох болзолыг хангах
8-р сар	Бүрэн дунд боловсролын гэрчилгээг баталгаажуулах
8-р сар – 1-р сар	ГЕРМАН ХЭЛНИЙ БЭЛТГЭЛ КУРС ОНЛАЙН: B1 > B2
Майнц руу нүүх <small>JOHANNES GUTENBERG UNIVERSITÄT MAINZ JGU</small>	
2-р сар – 7-р сар	ГЕРМАН ХЭЛНИЙ БЭЛТГЭЛ КУРС амжилттай дүүргэсний дараа ISSK-ийн үндсэн сургалтад хамрагдах
7-р сар	ТТШ-д тэнцсэний дараа мэргэжлийн сургалтад хамрагдах